

## КАЗАХСТАНД ХИЙЖ БУЙ ОЮУН САНААНЫ ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Калыбек Кобландин*

*Энэхүү өгүүлэлд Казахстанд өрнөж буй казах хэлийг үе шаттайгаар, хурдацтайгаар латин бичиг үсэгт шилжүүлэх үйл явцын өрнөлийг тодотгон бичиж, энэ нь казах үндэстнийг дэлхийн олон соёлт орон зайд амжилттай нэгтгэн оруулах, дэлхийн хамтын нийгэмлэгийн соёл иргэнилийн үнэт зүйлсийг өөртөө мөн шингээн авах хосгүй боломжийг олгох тухай дурджээ. Орчин үеийн казахстанчуудын сэтгэхүйг өөрчилж, казах хэлийг “кирилл” үсэгнээс “латин” бичигт шилжүүлснээр Казахстаны нийгмийг Баруун Европын олон хэлтэй харилцдаг болгоод зогсохгүй, мөн өөрийгөө хуучин дарангуйллын үеийн тогтолцооноос ангижируулж чадсан, огт өөр иргэний нийгэм болсон гэдгээ батлан харуулж чадах тухайд зохиогч онцлон тэмдэглэжээ.*

**Түлхүүр үг:** *Казахстан, Н.Назарбаев, улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санааны шинэчлэл, латин бичиг үсэг*

Нэг талаас, олон улсын харилцааны тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, дэлхийн улс төрийн бодлогод шинэ бодит байдал үүсэн бий болж, улс хоорондын болон орон нутгийн зөрчилдөөн хүчтэй болж, нөгөө талаас, эдийн засагт хаа сайгүй технологийн дэвшил гарч, боловсролын тогтолцоо интеграцичлагдах үйл явц болж, шашины урсгалууд нэг нэгэндээ харилцан нөлөөлж байгаа

нь өнөөгийн Казахстаны нийгмийн өмнө тавигдаж буй тэргүүлэх зорилтуудын нэгээр улс үндэстний эв нэгдлийг хадгалан үлдээж, соёлын өвөө арвижуулах явдал болоод байна.

Даяаршиж өөрчлөгдөнө гэдэг нь нийгмийн хөгжлийн хувьд эерэг төлөвтэй байхаас гадна улс үндэстний өвөрмөц төрх байдлыг арилгаж үгүй болгох эрсдэлийг агуулахаас гадна, Казахстаны хойч үеийхэнд үндэснийхээ соёлын өв баялгийг гээх аюул заналыг дагуулж байж болно.

Төрийн тэргүүн Н.Назарбаев Казахстаны ард түмэнд танилцуулсан “Ирээдүйг харахад: нийгмийн ухамсарыг шинэчлэх нь” Илгээлтэндээ “үндэснийхээ эв эеийг хадгалан үлдээх нь чухал. Үндэсний уламжлал ба ёс заншил, хэл ба дуу, хөгжим, уран зохиол ба хуримлах ёсон гээд, нэг үгээр хэлбэл, үндэстний оюун санаа ард түмэнтэй мөнхөд оршин байх ёстой юм” – хэмээн онцлон тэмдэглэсэн нь уг үйл явцыг цагийг нь олж ухамсарласныг тусгаж байна.

Үеэ өнгөрүүлж, хоцрогдсон зарим зан үйлдэлээсээ салах шаардлага нь өнөөгийн казах үндэстний төлөөллийг хийлийн чанадад суугаа ард түмнийхээ төлөөлөгчдийн хувь тавиланг өөрөөр харахад хүргэж байгаа юм.

Өнөөгийн геополитикийн хямрал (орон нутаг болон бүс нутгийн цэрэг дайны мөргөлдөөн)-ын улмаас тархаж буй яс үндэсээр нь гадуурхан үзэн ядах, шашны хэт даврагсдын хүчээ авч буй хандлага, алан хядлагын аюул зэрэг сөрөг нөлөөнд хүссэн хүсээгүй өртөж болзошгүй байгаа харьд суугаа казах үндэстэний хувь заяа бид бүхний сэтгэл санааг ихэд түгшүүлж байна.

Өдгөө үндэстнээ омог, отог, бүлэг болгон хувааж, олон жилийн турш нийгэмээ дотор нь хагалан бутаргаж, чингэснээр орчин цагийн дэлхийн өөрчлөгдөн буй үйл явцтай хөл нийлүүлэн явах чадваргүй болгосоор ирсэн байдал улам бүр холдсоор байна.

1990-ээд оны эхээр Бүгд Найрамдах Казахстан Улсын Төрийн тэргүүний санаачлагаар эхлүүлсэн “оралман”-уудыг дэмжих улсын хөтөлбөрийн хүрээнд казах үндэстнүүд Казахстанд эргэн ирж, “Соёлын өв” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад түүхэн дурсгалт үнэт зүйлсийг эх орондоо эгүүлэн авч ирж, олон тооны хөшөө дурсгалыг сэргээн засварлаж, хаа сайгүй археологийн болон угсаатан зүйн эрэл

хайгуул хийж буй нь казах үндэстний нэгэн үед үрж гээгдүүлсэн өөрийн гэсэн өвөрмөц байдлын үндэс суурийг шинээр сэргээж, үндэснийхээ уламжлал, ёс заншил, соёлоо сэргээж, хэл, уран зохиол, дуу, хөгжим, аман зохиолын гоо сайхныг сэргээн босгосоор байна.

1917 оны хувьсгалын “Аравдугаар сарын эргэлт”, 1920-иод оны өлсгөлөн, 1930-аад оны хүчээр иргэдийн эд хөрөнгийг хураан авч, хамтралжуулж, улс төрийн хэлмэгдүүлэлт хийж, Казахстан руу олон мянган үндэстнийг нутаг заан цөлж, атар газрыг эзэмшиж байсан зэрэг нь тус улсын оршин суугч казах иргэдийн тоог цөөрүүлэхэд хүргэсэн: казах үндэстний олонх нь амь үрэгдэж, амьд үлдэгсэд нь Эх орноо орхин, соёл, оюун санаа, үндэснийхээ хэлтэрхийг аван одсон юм.

Хятад, Монгол, Турк, Афганистан, Пакистан, Иран, Европын улс орнууд бидний эх орон нэгтнүүдэд аврал болж, олон үе удмынхны төрөлх оргонол нь болсон юм.

Өдгөө ч гэсэн харьд суугаа казахууд үндэстнийхээ ген, оюун санааг тээгчийн хувьд үндэсний эв эе, нэгдэл, түүнийг арвижуулан авч явахад үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсаар байна.

Өнөөгийн казахстанчуудын гэтлэн давж гарах ёстой нэгэн зүйл бол Казахстаны Ерөнхийлөгчийн, казах хэлийг үе шаттайгаар, мөн үүний зэрэгцээ хурдацтайгаар латин бичиг, үсэгт шилжүүлэх уриалга болоод байна. Чингэснээр казах үндэстнийг дэлхийн олон соёлт орон зайд амжилттай нэгтгэн оруулахын зэрэгцээ, дэлхийн хамтын нийгэмлэгийн соёл иргэншлийн үнэт зүйлсийг өөртөө мөн шингээн авах хосгүй боломжийг олгох юм.

Орчин үеийн казахстанчуудын сэтгэхүйг өөрчилж, казах хэлийг “кирилл” үсэгнээс “латин” бичигт шилжүүлснээр Казахстаны нийгмийг Баруун Европын олон хэлтэй харилцдаг болгоод зогсохгүй, мөн өөрийгөө хуучин дарангуйллын үеийн тогтолцооноос ангижируулж чадсан, огт өөр иргэний нийгэм болсон гэдгээ батлан харуулах юм.

Бидний үзэж буйгаар, латин бичигт шилжин орсноор тус улсын уугуул биш, өөр хэлтэй олон хүн ам казах хэлийг төрийн хэлнийх нь хувьд сурч судлахад нь сонирхолтой бөгөөд чухал үйл явц болох буйзаа.

Латин бичиг олон хүний хувьд шинэ технологи, компьютер,

үйлчилгээний чанартай холбоотойгоор янз бүрийн ойлголт төрүүлдэг. Тухайлбал, нэг их “баруунжаад” байх дургүй Япон, Хятад зэрэг улс нь латин бичгийг ашиглан итгэлтэйгээр дэлхийн зах зээлд гарсан явдал юм. Үүнээс гадна латин бичиг “брэнд” график болсноо харуулаад байна.

Казах залуусын гадаад хэлийг эзэмших гэсэн эрмэлзэл, тэмүүлэл, нийгэм цахимжиж байгаа байдал, Интернетийн ашиглалт, телевиз, кино, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон соёлын харилцан нөлөөлөл, чанартай аж төрөх ёсон, хэв маягт шилжих гэсэн хүсэл эрмэлзэл зэрэг нь манай нийгмийг латин бичгийг нааштайгаар хүлээн авахад нь тууштай бөгөөд хэлбэрэлтгүй урагшлуулж байна.

Турк, Афганистан, Узбекистан, Туркменистанд оршин суугаа казахууд болон Монгол Улсын казах иргэд үндэснийхээ хэлээр хоорондоо харилцахдаа латин бичигт үндэслэсэн орчин цагийн цахим мэдээллийн сүлжээг улам бүр ашигласаар байна.

Олон улсын харилцааны туршлагаас харахад өөр өөрсдийн бичиг үсэгтэй мөртлөө өөр хоорондоо харилцан ашигтай хамтын ажиллагаа, нягт харилцаатай хэсэг улс орон (Армян, Гүрж, Гэрэг, Хятад, Израиль г.м.) байна.

БНКазахстан Улс дэлхийн улс төр, эдийн засаг, соёл-хүмүүнлэгийн салбар дах үйл явцад идэвхтэй оролцсоор байна. Тогтвортой байдал, Казахстаны улс төрийн бодлогыг урьдчилан таамаглах боломжтой, Казахстанд бизнес хийх тааламжтай нөхцлийг бүрдүүлсэн байдал зэрэг нь гадаадын компаниудын Казахстаны нутагт ирэх сонирхолыг ихэд татдаг.

Тухайлбал, Дэлхийн эдийн засгийн форумын рейтингээр 2015-2016 оны өрсөлдөх чадвараараа Казахстан 42 дугаар байранд, АНУ-ын “The Heritage Foundation” судалгааны төвийн рейтингт 2016 онд эдийн засгийн чөлөөт байдлаараа мөн 42 дугаар байранд, Дэлхийн банкны “Doing Business” рейтингт 35 дугаар байранд шалгарч, 4 жил дараалан хамгийн сайн “реформатор”(өөрчлөн байгуулагч)-аар шалгараад байна.

Ийнхүү Казахстан улс дэлхий дээр болж буй үйл явцад идэвхтэй оролцож байгаа нь гадаадын иргэдийг манай орныг, үүний дотор казах хэлийг идэвхтэй сонирхдог болгож байна.

Гадаадын олон компани Казахстантай харилцаж, хамтран

ажиллахыг төлөвлөхдөө, ажилтнуудаа казах хэл сурахыг дэмжиж байна. Иймд гадаадын иргэдийг казах хэлийг сурахыг нь латин бичиг үсэг нэлээд хөнгөвчилж өгч байгаа болов уу. Үүнээс гадна казах бичгийг латин бичигт шилжүүлэх явдал нь Казахстаны аялал, жуулчлалын салбарт эерэгээр нөлөөлөх буйзаа.

Ерөнхийдөө Казахстанд хийж буй улс төр-эдийн засгийн, нийгэм-оюун санааны шинэчлэлийн эцсийн зорилго нь тус улсыг өөрийгөө хөгжүүлж, механизмаа байнга шинэчилж байх чадвартай, цаг үеийн шаардлага, сорилтонд зохицсон тогтолцоо болгох явдал юм гэж хэлж болно.

Энэ утгаараа Казахстаны Ерөнхийлөгчийн улс орон, нийгмийг системтэй, тууштай хувьсган хөгжүүлэхэд чиглэсэн оюун санааны шинэчлэлийн салбарт төрийн бодлогын хэлхээ холбоо, залгамжлах чанарт анхаарлаа хандуулан гаргасан уриа нь цагаа олсон, тулгамдаад байгаа, гүнээ ухамсарлахыг, бүх ард түмний дэмжлэгийг шаардсан зүйл юм.